МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 21 өдөр Дугаар А/477 Есөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын Оргил багт шинээр баригдсан 18 айлын орон сууцны барилгыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Б.Бямбадорж | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор) |
| Гишүүдэд: | М.Мандаххүү | (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга) |
| | Б.Батбилэг | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч) |
| | П.Аззаяа | (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч) |
| | Б.Цэрэндаваа | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер) |
| | Г.Хүрэлхүү | ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ерөнхий инженер) |
| | Б.Бээжин | ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер) |
| | Д.Цэвэлмаа | ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер) |



0201000680

2.

А.Отгонбаатар (“Мандал голомт” ХХК-ийн ерөнхий инженер)

Л.Нямдаваа (“Пико инженеринг” ХХК-ийн архитектор) (Зохиогч)

Нарийн бичгийн дарга:Ц.Мөнхцэцэг (“Өргөө засал” ХХК-ийн захирал)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА О.АМГАЛАНБААТАР

0201006394